



Давхар татварын гэрээнүүдэд өөрчлөлт орно

Холбоо барих:

Майкл Ахэрн

Партнер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
michael.ahern@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Жамбалын Энхзул

Менежер
Татварын зөвлөх үйлчилгээ
enkhzul.jambal@pwc.com

Эрдэнэ-Очирын Энхсанаа

Менежер
Татварын зөвлөх үйлчилгээ
enkhsanaa.erdene-ochir@pwc.com

ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК

Сентрал Тауэр, 6 давхар
601 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
Факс : +976 11 322068
www.pwc.com/mn

Олон талт хэрэглүүр (ОТХ)-ийн талаар дэлгэрүүлэн хэлэлцэх, эсхүл танай бизнесийн үйл ажиллагаанд ОТХ-ийн үзүүлэх нөлөөллийг үнэлэхэд мэргэжлийн туслалцаа хэрэгтэй бол бидэнтэй холбогдоно уу.

Товч агуулга

Олон Талт Хэрэглүүр (ОТХ) гэж мөн нэрлэгддэг Татварын суурийг гажуудуулах, ашиг шилжүүлэх (ТСГАШ) явдлаас урьдчилан сэргийлэх татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх тухай Олон Талт Конвенци нь татварын гэрээтэй холбоотой ТСГАШ (BEPS)-ийн эсрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой тухайн улсын баримтлах татварын бодлогуудын дагуу татварын гэрээнд өөрчлөлт оруулахад чиглэсэн уян хатан хэрэгсэл юм.

Монгол Улс 2022 оны 10-р сарын 6-нд дээрх Олон Талт Конвенц нэгдэн орохоор гарын үсэг зурснаар, дэлхийн улс орнуудын хооронд байгуулсан нийт 1850 гаруй хоёр талын татварын гэрээг хамраад буй уг Конвенцод нэгдэн орсон 100 дахь улс болсон.

Улмаар, ОТХ нь УИХ-ын 2023 оны хаврын чуулганаар соёрхон батлагдахаар төлөвлөгдөж байна. Энэ тохиолдолд, Монгол улсын одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй давхар татварын гэрээ (ДТГ)-нүүдэд 2024 оны 1-р сарын 1-ээс эхлэн өөрчлөлт орох юм.

Дэлгэрэнгүй

ОТХ хүчин төгөлдөр болох процессын хувьд, юун түрүүнд УИХ-аас ОТХ-ийг соёрхон батлах ёстой ба үүний дараа соёрхон батлагдсан талаарх нот бичгийг дипломат шугамаар ЭЗХАХБ-д хүргүүлэх ёстой. Ингэснээр соёрхон батлагдсан талаарх зохих ёсны мэдэгдлийг эрх бүхий байгууллагуудаас нь хийсэн ОТХ-үүдийн “хамрах” ДТГ-нүүдийн хувьд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ.

Монгол Улс нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй **нийт 26 ДТГ**-гээ бүгдийн ОТХ-д хамруулах сонголтыг хийсэн байна. Гэхдээ, тухайлсан ДТГ-нд ОТХ-ийг мөрдөхийн тулд гэрээний нөгөө тал болох Хэлэлцэн Тохирогч нөгөө улс тухайн ДТГ-г мөн ОТХ-ийн хамрах ДТГ-нүүдийн жагсаалтдаа оруулсан байх ёстой. ЭЗХАХБ-аас гаргасан мэдээллээс харахад манай улстай ДТГ-тэй **17 улс** Монгол Улстай байгуулсан ДТГ-ээ ОТХ-д хамруулах сонголтыг одоогийн байдлаар хийсэн байна. ОТХ-ийг соёрхон баталсны дараа ч улс орнууд хамрах ДТГ-нүүдийн жагсаалтдаа нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой юм.

ОТХ-ийн хүчин төгөлдөр болсноор Монгол улсын хамрах ДТГ-нүүдийн удиртгал буюу гэрээний зорилго хэсэгт дараах нэмэлт хийгдэнэ: “... татвараас зугтах эсхүл зайлсхийх замаар татвар ногдуулахгүй байх, эсхүл бууруулсан хэмжээгээр татвар төлөх боломжийг олгохгүйгээр энэ гэрээнд хамаарах татваруудад давхар татвар ногдуулахгүй байхад чиглэнэ”. Энэхүү нэмэлт өөрчлөлт орсон удиртгал хэсэг нь татвараас зугтах эсхүл зайлсхийх замаар (гуравдагч улсын татвар төлөгч ДТГ-г урвуулан ашиглах замаар ДТГ-ний өгөөжийг шууд бусаар ашиглах явдлыг оруулаад) татвар ногдуулахгүй байх, эсхүл бууруулсан хэмжээгээр татвар төлөх боломжийг эдлэх зорилгоор ДТГ-г ашиглаж болохгүй гэдгийг бататгаж байгаа юм.



Давхар татварын гэрээнүүдэд өөрчлөлт орно (үргэлжлэл)

Холбоо барих:

Майкл Ахэрн

Партнер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
michael.ahern@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Жамбалын Энхзул

Менежер
Татварын зөвлөх үйлчилгээ
enkhzul.jambal@pwc.com

Эрдэнэ-Очирын Энхсанаа

Менежер
Татварын зөвлөх үйлчилгээ
enkhsanaa.erdene-ochir@pwc.com

ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК

Сентрал Тауэр, 6 давхар
601 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
Факс : +976 11 322068
www.pwc.com/mn

Олон талт хэрэглүүр (ОТХ)-ийн талаар дэлгэрүүлэн хэлэлцэх, эсхүл танай бизнесийн үйл ажиллагаанд ОТХ-ийн үзүүлэх нөлөөллийг үнэлэхэд мэргэжлийн туслалцаа хэрэгтэй бол бидэнтэй холбогдоно уу.

Цаашилбал, Монгол улсын сонгосон дүрмүүд, хийсэн мэдэгдэлтэй холбоотойгоор ДТГ-ний Хөрөнгө борлуулсны олз (13-р зүйл), болон Төлөөний Газрыг тодорхойлох шалгуур (5-р зүйл)-т хамаарах зарим зүйлүүдэд өөрчлөлт орохоор байна. Түүнчлэн, хил дамнасан ажил гүйлгээнд мэдэгдэхүйц татварын нөлөө үзүүлэх бусад өөрчлөлтүүд ДТГ-нүүдэд мөн орохоор байна.

ОТХ-ийн хамгийн чухал үзэл санаа, ДТГ-нүүдэд оруулах гол өөрчлөлтүүд нь Үндсэн Зорилгын Тест (“ҮЗТ”) болон Өгөөжийн Заалтуудыг Хязгаарлах Хялбаршуулсан Дүрэм (“ӨЗХХД”)–ээр дамжин хэрэгжих татвараас зайлсхийхийн эсрэг шинэ арга хэмжээнүүд байх болно гэж дүгнэж болох юм. Аливаа хэлцэл эсвэл ажил гүйлгээний **үндсэн зорилгын нэг** нь гэрээний өгөөжийг хүртэх явдал бол (ДТГ-ний холбогдох заалтын зорилгоор гэрээний өгөөжийг хүртэх эрхтэйгээс бусад тохиолдолд) **ҮЗТ**-ээр уг ажил гүйлгээнд гэрээний өгөөжийг хүртэх эрхийг ерөнхийдөө хязгаарлана. **ӨЗХХД** нь илүү нарийн зохицуулалттай бөгөөд хэд хэдэн шалгуурууд (шаардлага хангасан этгээд, идэвхтэй бизнесийн үйл ажиллагааны тест гэх мэт)-ыг хангаж байж ДТГ-ний өгөөжийг хүртэх эрхтэй болно гэж шаарддаг.

Товч дүгнэлт ба бидний туслалцаа

ОТХ хүчин төгөлдөр болсноор ДТГ-ний хэрэглээний дүрмүүдэд мэдэгдэхүйц өөрчлөлт орно. Тухайлбал, аливаа хэлцэл эсвэл ажил гүйлгээний **үндсэн зорилго** нь ДТГ-ний өгөөжийг хүртэх явдал болох нь холбогдох бүх баримт бичиг, нөхцөл байдлаар нотлогдож байвал ДТГ-ний өгөөжийг хүртэх эрхгүй болно. Тиймээс, татвар төлөгчид ОТХ-ийн хүрээнд ДТГ-нд орох өөрчлөлтүүд, шинэ дүрмүүд нь тэдний олон улсын бизнесийн үйл ажиллагаа, хил дамнасан санхүүгийн ба холдинг бүтэц, хэлцэл болон ажил гүйлгээнд хэрхэн нөлөөлөхийг урьдчилан үнэлж үзэх нь чухал юм.

Таны бизнесийн үйл ажиллагаанд ОТХ-ийн үзүүлэх нөлөөллийг тодорхойлж, үнэлэхэд бид туслахдаа таатай байх болно.

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл (эс үйлдэл) хийхээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашиглан хийсэн үйлдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2022 Бүх эрх хуулиар нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурьдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.

